



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/383

Хэрлэн сум

Пара волейболын 21 дэх удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Архангай аймагт зохион байгуулагдах Пара волейболын 21 дэх удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бүрдсэн баг тамирчдыг зохион байгуулж оролцуулах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төрийн бус байгууллагуудыг түшиглэн нийтийн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ